



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

┌ Барилга акталж, нийслэлийн өмчийн
бүртгэлээс хасах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барилга баригдах болсонтой холбогдуулан Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын баланст бүртгэлтэй, 14 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга болон газрын зөрчил арилгах, газар чөлөөлөх ажлын хүрээнд буугдсан нийслэлийн ерөнхий боловсролын 30 дугаар сургуулийн баланст бүртгэлтэй граж, нийт 19,872,768.37 (арван есөн сая найман зуун далан хоёр мянга долоон зуун жаран найман төгрөг гучин долоон мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, хавсралтад дурдсан 2 барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100366

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 103
дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглал -тад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2022.09.30/	Үлдэгдэл өртөг /2022.09.30/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга	1996	Баянзүрх дүүрэг, 14-р хорооны цогцолборын дэргэд, Нарантуул захын хойно	18,015,654.37	4,718,385.76	13,297,268.61	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2022 оны 02-07-081/870 дугаар дүгнэлт
2	Нийслэлийн ерөнхий боловсролын 30 дугаар сургуулийн гараж	1996	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, Отгонтэнгэр их сургуулийн хойно	1,857,114	497,441.25	1,359,672.75	НЗД-ын 2022 оны А/388 дугаар захирамжийн дагуу газрын зөрчил арилгах, газар чөлөөлөх ажлын хүрээнд буугдсан.
НИЙТ ДҮН				19,872,768.37	5,215,827.01	14,656,941.36	